



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/90

Амардалай

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 11.436.500 (Арван нэгэн сая дөрвөн зуун гучин зургаан мянга таван зуун) төгрөгийн санхүүжилтээр хийгдэж буй "Сумын төвийн орчны тохижилт, хур хог хаягдлыг арилгах" ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Золжаргал (Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга: Б.Баатарсүрэн (3-р багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Сосорбурам (2-р багийн Засаг дарга)

Б.Довуучий (1-р багийн Засаг дарга)

Б.Баттогтох (Байгаль орчин хариуцсан мэргэжилтэн)

Б.Баярмаа (ЗДТГ-ын нярав)

Д.Чунт (Иргэний төлөөлөл)

2. Сумын төвийн орчны тохижилт, хур хог хаягдлыг арилгах ажил нь ажлын даалгаварт тусгагдсаны дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьж, чанарын шаардлагад нийцсэн ажлыг хүлээн авах, холбогдох акт баримтыг журмын дагуу үйлдэж, бүрдүүлэхийг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

